

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН
НИЙТИЙН ТӨВ НОМЫН САН

ТАЙЛАН

2025 оны 6 дугаар сарын 03

Улаанбаатар хот


Номын сангийн ёс зүйн зөвлөлийн
2025 оны хагас жилд хийж гүйцэтгэсэн ажлын тухай

Тус номын сангийн ёс зүйн зөвлөлийн гишүүд нь ажилчдыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, хууль тогтоомжид заасан эрх үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, харилцааны болон ёс зүйн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

- ✓ Тайлант хугацаанд Ёс зүй гэж юу вэ? сэдэвт сургалтыг Ёс зүйн зөвлөлийн гишүүн А.Энхжаргал удирдан явуулж ЧД дүүрэг дэх салбар номын сангийн ажилтнуудад мэдлэг, мэдээлэл өгч сургалтад нийт 5 ажилтан албан хаагч хамрагдсан.



- ✓ Ёс зүйн зөвлөлийн гишүүд Ажилтны сэтгэл ханамжийн судалгаа, номын сангаар үйлчлүүлж буй уншигч хэрэглэгчдээс ажилтан, албан хаагчдын харилцаа хандлагын талаарх судалгаа авч, үр дүнг нэгтгэн танилцуулсан. Судалгаанд нийт 23 албан хаагч 50 уншигч хамрагдсан.
- ✓ Байгууллагад шинээр ажилд орж байгаа ажилтнуудад тухайн байгууллагын дүрэм, журам, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, хууль тогтоомжид заасан хүний эрх чөлөөг хүндэтгэх, харилцааны болон ёс зүйн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээ, мэдээллийг ёс зүйн зөвлөлийн дарга М.Отгонбаяр өгсөн.
- ✓ Албан хаагч нарыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Төрийн туульч СГЗ Э.Баатаржав “ Алтайн магтаал”, Баян цагаан өвгөн туульсыг хайлж, урианхайн ховор нандин соёлын өв болох тууль хайлах ёсны талаар танилцуулсан. Мөн “Гэмт хэрэг, ёс зүйн зөрчлөөс сэргийлье” сэдэвт ном гарын авлагаар үзэсгэлэн болон Ажилчдын дотоод цахим хуудсаар дамжуулан Дэлхийн ёс зүйн өдрийг тохиолдуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмуудыг таниулсан постер бэлтгэн хүргэсэн байна.



✓ Байгууллагын пэйж хуудсаар дамжуулан “Хүмүүжлийн хэв маяг”, Ёс суртахууны тухай ойлголт” цахим мэдээллийг 2 удаа бэлтгэн хүргэсэн.



ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН
ЗАХИРАЛ

Д.ИНДРА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН
ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

М.ОТГОНБАЯР

